



БАЙГАЛИЙН ШИНЖЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН СУРГУУЛЬ

213500 Ховд аймаг Утас: (77006905)
E-mail: khu@khu.edu.mn

№ _____

Хичээлийн тодорхойлолт хүргүүлэх тухай

ХИС-ИЙН БАЙГАЛИЙН ШИНЖЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН СУРГУУЛИЙН ХИМИЙН ТЭНХИМИЙН БАГШ ДЭД ПРОФ А. АМАРЖАРГАЛ, МАТЕМАТИК МЭДЭЭЛЭЛ ЗҮЙН ТЭНХИМИЙН БАГШ ДЭД ПРОФ Д. ӨНӨРНАСАН БАГШ НАРТ

Ховд Их Сургуулийн Байгалийн Шинжлэл Технологийн сургуулийн Химийн тэнхимийн 2022-2023 оны хичээлийн жилд магистрын ангид заах “Хотын экологи” хичээлийг ХИС-ийн сургалтын журмын дагуу шинээр болон шинэчлэн боловсруулж байгаа хичээлийн хөтөлбөрийн талаар саналаа хүргүүлж байна. Үүнд:

“Хотын экологи” хичээлийн агуулгын хүрээнд хотын нөхцөлд экологийн тухай ойлголт, онолыг нэвтрүүлэх, Хотын тогтвортой хөгжлийг хангах био олон янз байдлыг хамгаалах, менежментийн зарчим, стратегийг тайлбарлах, уур амьсгалын өөрчлөлтийн дэлхийн сорилттой тэмцэх стратегийг хотуудад нэвтрүүлэх зорилготой хийсэн уг хичээлийн хөтөлбөр нь сүүлийн үеийн сургалтын арга зүйг ашиглан, хотын экологит шаардагдах мэдлэг чадварыг олгохуйц хөтөлбөр болсон байна.

Хөтөлбөрт өгөх санал

1. Янз бүрийн экологийн бүс бүслүүрт орших хотын экологийн өвөрмөц онцлог, ангилал, ялгаатай байдлыг сургалтын агуулгад оруулах
2. Хотын экологийн бохирдол, хүний эрүүл мэндэд нөлөөлөх нөлөө, түүнийг хүлцэх стандарт хэмжээ, бууруулах арга замтай холбоотой сэдэв нэмж оруулах
3. Хичээлийн даалгаврыг тодорхой ойлгомжтой болгох
4. Хичээлийн сэдвийн ард агуулгыг оруулж өгөх нь зүйтэй гэсэн саналтай байна.

Санал бичсэн:

Ховд их сургуулийн биологийн тэнхимийн эрхлэгч  Б.Ганчимэг

ЗАХИРАЛ



Н.ТЭГШЖАРГАЛ